



## RED LINE дугуйт унтраагуур

### Хүчтэй, авсаархан хамгаалалт

- Зөөвөрлөхөд нэн дөхөм, хэрэглэхэд хялбар
- бие даасан, нэг хүний ажиллагаа
- Ашиглалт ба засвар үйлчилгээ нь хялбар
- UL/ULC-д бүртгэгдсэн
- FM ба USCG баталсан
- Олон бодисын төрлүүд
- Зэврэлтэд тэсвэртэй өнгөлгөө
- Зургаан жилийн хязгаарлагдмал баталгаа

Том хэмжээний гал түймрийн аюулд орж болзошгүй бүсэд байгаа хүмүүсээ мөн өмч хөрөнгөө хамгаал ANSUL® RED LINE дугуйт гал унтраагуур нь эх үүсвэр дээр болон хамгийн хэцүү орчинд гал түймэртэй тэмцэх боломжийг нэг операторт олгоно.

### Том хэмжээний гал түймрийн эсрэг шуурхай хариу үйлдэл

RED LINE дугуйт хуурай химийн гал унтраагуур нь өндөр эрсдэлтэй галын аюулд зориулагдсан. Эдгээр үйлдвэрлэлийн дугуйт гал унтраагуур нь гар зөөврийн гал унтраагуураас илүү бодисыг агуулах хүчин чадалтай хирнээ зөөвөрлөхөд нэн дөхөм бөгөөд нэг хүн бүрэн удирдах боломжтой.

Том диаметртэй ган дугуй нь галын эх үүсвэр рүү гал унтраагуурыг хялбархан тээвэрлэх боломжийг олгох ба хурдан, хялбар ажиллуулахад зориулсан нэг хавхлагатайгаар зохион бүтээгдсэн. Дугуйт унтраагуур нь тодорхой төрлийн галд зориулан боловсруулсан хуурай химийн ба хуурай нунтаг бодисын сонголттойгоор ирдэг. Бүх дугуйт унтраагуур нь зэврэлтэд тэсвэртэй өнгөлгөөтэйгөөр үйлдвэрлэгддэг ба хурдан нээгдэх хавхлага, урт хэмжээтэй хошуу, тусгай дугуй зэргийг багтаасан сонголтуудыг санал болгодог.

### Таны хэрэглээнд тохирсон хоёр загвар

Дугуйт гал унтраагуур нь авсаархан байдал ба маневр хийх чадварыг хослуулсан туйлын гал унтраах хүчийг олгодог. C загвар нь том диаметртэй дугуй, азотын цилиндр ба бодисын савыг олгодог. Сайн тэнцвэр ба хялбар маневр хийхэд зориулж дугуйны голыг хүндийн төвтэй ойр байрлуулсан. Бүрэн бие даасан RED LINE C загварын дугуйт унтраагуур нь дараах унтраах бодисын сонголтуудыг агуулсан өндөр хүчин чадалтай сав бүхий онцлогтой юм. FORAY (Class ABC), Purple-K (Class BC), PLUS-FIFTY C (Class BC), MET-L-X (Class D), MET-L-KYL (Pyrophoric) ба LITH-X (Class D).

D загвар нь тээвэрлэлтийн жинг багасгах, маневр ба хялбар хадгалалтад зориулсан жижиг диаметртэй дугуй, азотын цилиндр болон богино бодисын сав бүхий илүү авсаархан, хэмнэлттэй унтраагуур юм. Бүрэн бие даасан RED LINE D загварын дугуйт унтраагуур нь дараах хуурай химийн унтраах бодисын сонголтуудыг агуулсан өндөр хүчин чадалтай сав бүхий онцлогтой юм. FORAY, Purple-K ба PLUS-FIFTY C.

RED LINE дугуйт C ба D загвар нь хоёулаа 150 фунт (68 кг) ба 350 фунт (159 кг)-ын хэмжээтэйгээр ирдэг. (Бодит багтаамж нь сонгосон бодисоос хамаарна.)





## RED LINE ДУГУЙТ ГАЛ УНТРААГУУРЫН ХЭРЭГЛЭЭ

Нисэх буудлын байгууламж

Дүрэх ба хөргөх сав

Түлш ачаалах тавиур

Түлш хадгалах талбай

Хүнд барилгын талбай

Ачаалах тавцан

Уурхайн тоног төхөөрөмж

Задгай далайн талбай

Тос шахах станц

Будаг шүрших кабин

Үйлдвэрлэлийн дамжлага

Ган, төмрийн үйлдвэр

Үйлдвэрлэлийн бүс

### Цэвэрлэгээгүйгээр унтраах

RED LINE нүүрстөрөгчийн давхар исэлтэй дугуйт унтраагуур нь В ба С төрлийн гал гарах боломжтой талбайг хамгаалахад зориулагдсан. Нүүрстөрөгчийн давхар исэлтэй, зэврүүлдэггүй, дамжуулдаггүй унтраах бодис нь галын дараа ямар ч үлдэгдлийг үлдээдэггүй. Бүтээгдэхүүний нэмэлт онцлогт энгийн, нэг хүний ажиллагаа ба засвар үйлчилгээ, зөөврийн, авсаархан загвар ба 16 инчийн (406 мм) хагас хийн резинэн дугуй багтана.

### Туйлын гал унтраах шийдэл

ANSUL брэнд нь автомат илрүүлэлт ба унтраах системээс эхлээд дугуйт, гар зөөврийн иж бүрэн гал унтраагч хүртэлх галын хамгаалалтын чанартай цогц шийдлийг амалдаг. Мөн эрх бүхий ANSUL-ын борлуулагчийн өргөн сүлжээ нь дэлхий даяарх харилцагчдад бодитойгоор үйлчлэхийн тулд үйлдвэрийн сургагдсан мэргэжилтнээр хангадаг.

### Хамгаалах хүсэл

Хэрэглэгчдээ чин үнэнчээр дэмжих Өргөн цар хүрээтэй бүтээгдэхүүний багц. Инженерчлэлийн төгс байдал Итгэмжлэгдэн батлагдсан брэнд Тусо галын хамгаалалтын бүтээгдэхүүн нь эдгээр бүх шинж чанарууд ба хамгаалах хүслийг санал болгодог. Энэ нь таны хамгийн үнэ цэнэтэй хүмүүс, эд хөрөнгө, бизнесийг хамгаалахад туслах шийдлийг бий болгоход биднийг жолоодож байгаа зүйл юм.